

Монлогистикс Холдинг ХХК-ийн ТУЗ-ийн
Ээлжит хурлын 2023 оны 07-р сарын 31-ний өдрийн
№ 23/ТУЗ/23 тоот тогтоол



Монлогистикс Холдинг ХХК

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

BOD-0109.P

“ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ”

Баримт бичгийн дугаар
BOD-0109.P

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ҮЙЛ ЯВЦЫН ДАРААЛАЛ, ПРОЦЕССИЙН ЗУРАГЛАЛ, АЛХМУУДЫН ТАЙЛБАР	4
ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ	10
ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА	11
ТАВ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ	11
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №1.....</i>	<i>12</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №2.....</i>	<i>13</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №3.....</i>	<i>14</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №4.....</i>	<i>15</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №5.....</i>	<i>16</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №6.....</i>	<i>17</i>
<i>Эрсдэлийн удирдлагын журмын хавсралт №7, №8, №9 /Файлаар/</i>	

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

Энэхүү журмыг Монложистикс группийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянахад баримталж ажиллана.

1.1.1 Толгой болон Охин компаниудын бизнесийн үйл ажиллагааны гол эрсдэлүүдийг (Боломж ба Аюул) илрүүлж, үнэлж, хяналт тогтоосноор болзошгүй сөрөг нөлөөлөл, ажлын алдааг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах, боломжийг хамгийн өндөр түвшинд ашиглах үйл ажиллагааг зохицуулна.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү журам нь Монложистикс группийн толгой болон охин компаниудын бүхий л үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

1.3 Журмыг хариуцагч

1.3.1 Энэхүү журмын байнгын хэрэгжилтийг Монложистикс группийн толгой компанийн Аудит, эрсдэлийн удирдлагын хороо, /КЗК. Хавсралт 8-2.3/ харин эрсдэлийг тодорхойлж, үнэлж, хяналт тогтоох ажлыг толгой болон охин компаниудын Гүйцэтгэх удирдлага өөрийн компанийн эрсдэлийн баг, бусад зохион байгуулалтын нэгжээрээ дамжуулан хэрэгжүүлнэ. /КЗК. Хавсралт 8-4.2/

1.3.2 Дотоод аудитор нь группийн толгой болон охин компаниудын эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хянаж, үр дүнг сайжруулах зөвлөмж өгч ТУЗ-ийн АЭУХ-нд танилцуулж журмын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж ажиллана. /КЗК. 4.3 тайлбар 1/

1.3.3 Энэ журмын гүйцэтгэлийн хэмжүүр нь дараах үзүүлэлтээр илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Толгой болон охин компаниудын бизнесийн ба тактикийн түвшний эрсдэлүүд жил бүр тогтмол шинэчлэгдсэн байх,
- Гол /10-25/ зэргийн эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээнүүд компаниудын урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөнд сууж батлагдсан байх,
- Дотоод ба гадаад аудитаар эрсдэлийн удирдлагатай холбоотой үл нийцэл гарахгүй байх,

1.4 Нэр томъёоны тайлбар

1.4.1 **Эрсдэл (risk):** Компанийн бизнесийн зорилгод нөлөөлөх ирээдүйн тодорхой бус үйл явдал ба нөхцөл байдал;

1.4.2 **Аюул (threats):** Компанийн бизнесийн зорилгод сөргөөр нөлөөлөх ирээдүйн тодорхой бус үйл явдал ба нөхцөл байдал;

1.4.3 **Боломж (opportunities):** Компанийн бизнесийн зорилгод эерэгээр нөлөөлөх ирээдүйн тодорхой бус үйл явдал ба нөхцөл байдал;

1.4.4 **Асуудал (issues):** Компанид аль хэдийн тохиолдоод байгаа үйл явдал, нөхцөл байдал;

1.4.5 **Бизнесийн эрсдэл (Business risk):** бизнесийн зорилго, үйл ажиллагаанд бүхэлд нь нөлөөлж (эерэг ба сөрөг) болох гадаад, дотоод орчны үйл явдал, нөхцөл байдал;

1.4.6 **Тактикийн эрсдэл (Tactical risk):** Компанийн аль нэг хэлтэс, нэгж, төслийн зорилго үйл ажиллагаанд нөлөөлж (эерэг ба сөрөг) болох гадаад, дотоод орчны үйл явдал, нөхцөл байдал;

1.4.7 **Үйл ажиллагааны эрсдэл (Operational risk):** Компанийн тухайн нэг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, үйлчилгээний эрсдэл;

1.4.8 **Зөвшөөрч болох эрсдэл (Risk appetite):** Зорилго, нөөцөө харгалзан тухайн компанийн хүлээн авахад бэлэн байгаа эрсдэлийн (боломж ба аюул) түвшин;

1.4.9 **Тэвчих эрсдэл (Risk tolerance):** Компанийн хүлээн авахад бэлэн байгаа эрсдэлээс хазайх түвшин;

1.4.10 **Үлдэгдэл эрсдэл (Residual risk):** Компани эрсдэлд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсний дараа үлдэж байгаа эрсдэл;

1.4.11 **Эрсдэлийн эх үүсвэр (Risk source):** Эрсдэлийг өсгөж болзошгүй дан эсвэл бүлэг элементүүд;

- 1.4.12 **Эрсдэлийн удирдлага (Risk management):** Эрсдэлтэй холбоотойгоор компанийг чиглүүлэх, хянах зохион байгуулалттай үйл ажиллагаа;
- 1.4.13 **Эрсдэлийг хариуцагч (Risk owner):** Эрсдэлийг хариуцаж бууруулах үүрэгтэй эрх мэдэл, үүрэг хариуцлага бүхий нэгжийн удирдлага болон ажилтан
- 1.4.14 **Групп компани:** Толгой болон охин компаниудын нэгдлийг;
- 1.4.15 **Толгой компани:** Үйл ажиллагаагаа уялдуулах зорилгоор байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээс бусад тохиолдолд хараат болон охин компанийн үйл ажиллагаанд зөвхөн эзэмшиж байгаа хувьцааныхаа эрхээр оролцдог Монлогистикс Холдинг ХХК-г;
- 1.4.16 **Охин компани:** Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг;
- 1.5 Товчилсон үгийн жагсаалт:**


ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ГЗ	Гүйцэтгэх захирал
ЭБ	Эрсдэлийн баг
АЭУХ	Аудит, эрсдэлийн удирдлагын хороо
ДА	Дотоод аудитор
З	Газар, хэлтсийн захирал
М	Менежер
А	Ажилтан

ХОЁР. ҮЙЛ ЯВЦЫН ДАРААЛАЛ, ПРОЦЕССИЙН ЗУРАГЛАЛ, АЛХМУУДЫН ТАЙЛБАР

2.1 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл явц

Орц	Үйл ажиллагаа	Оролцогч талууд							Гарц
		ТУЗ	ГЗ	ЭБ	З	ДА	М	А	
Эрсдэлийн үнэлгээний боломжит аргууд, ISO 31010 стандарт, компанийн орчин нөхцөл, өмнөх түүх	1. Хамрах хүрээ, нөхцөл байдал, шалгуур тогтоох	Мэдээлэл авах	Хянах	Хийх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах	Хийх		Эрсдэлийн үнэлгээний сонгогдсон арга, хэрэгсэл
Эрсдэлийн үнэлгээний сонгогдсон арга, хэрэгслүүд + SWOT шинжилгээ + Сонирхогч талуудын шинжилгээ + Процесс зураглал + Төслийн төлөвлөгөө г.м	2. Эрсдэлийн үнэлгээ хийх	Мэдээлэл авах	Хянах	Хийх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах	Хийх		Эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн бүртгэл
Эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн бүртгэл	3. Эрсдэлийг шийдвэрлэх	Мэдээлэл авах	Хянах	Хийх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах	Хийх		Эрсдэлийн шийдвэрлэлт, эрсдэлийн бүртгэл
Эрсдэлийн үнэлгээний тайлан, эрсдэлийн бүртгэл, эрсдэлийн шийдвэрлэлт	4. Эрсдэлийн үнэлгээний тайланг мэдээллэх зөвлөлдөх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах		Хийх	Мэдээлэл авах	Хийх	Мэдээлэл авах	Оролцооны бүртгэл
Эрсдэлийн бүртгэл тайлангийн загвар	5. Бүртгэл, тайлагнал	Мэдээлэл авах	Хийх		Хийх	Мэдээлэл авах	Хийх	Мэдээлэл авах	Эрсдэлийн бүртгэл, тайлан
Эрсдэлийн бүртгэл, тайлан, Эрсдэлийн удирдлагын журам	6. Эрсдэлийн мониторинг, дүн шинжилгээ	Мэдээлэл авах	Мэдээлэл авах		Мэдээлэл авах	Хийх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах	Сайжруулалтын санаачлагууд

2.2 Процессийн зураглал



Phase

2.3 Үйл явцын алхамуудын тайлбар

2.3.1	<p>Хамрах хүрээ, нөхцөл байдал, шалгуур тодорхойлох</p> <p><i>а. Компани нь эрсдэлийн удирдлагыг нэгдмэл байдлаар хийх зорилт тавьж ажиллах ба хамгийн багадаа дараах ангилалын эрсдэлийн үнэлгээг хэрэгжүүлнэ.</i></p> <p><u>1. Гадаад орчны эрсдэл</u></p> <ul style="list-style-type: none">- Гадаад хүчин зүйлсээс шалтгаалан бизнесийн стартеги зорилго амжилттай, үр дүнтэй хэрэгжихэд нөлөө үзүүлэхүйц эрсдэл- Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсхийг үнэлэх <i>КЗК-5.3</i> <p><u>2. Дотоод орчны эрсдэл</u></p> <ul style="list-style-type: none">- Компанийн дотоод хүчин зүйлсээс шалтгаалан бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц эрсдэл <p><u>3. Санхүүгийн эрсдэл</u></p> <ul style="list-style-type: none">- Гадаад дотоод хүчин зүйлсээс шалтгаалан компанийн өмч хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх эрсдэл <p><u>4. Нийцлийн /хууль, дүрэм, журам/ эрсдэл</u></p> <ul style="list-style-type: none">- Гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалан үл нийцэл үүсэх эрсдэл- Нэр хүндийн эрсдэл <p>Эдгээрээс гадна компанийн онцлог, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртөй холбоотой эрсдэлийн зайлшгүй шаардлагтай чиглэлийг тодорхойлж үнэлгээ хийнэ.</p> <p><i>б. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь дараах түвшинтэй байна.</i> Эрсдэлийг бизнесийн, тактикийн, үйл ажиллагааны гурван түвшинд <i>Хавсралт №1</i> “Эрсдэлийн удирдлагын түвшин”-нд заасан аргуудыг ашиглан үнэлэх ба цаашид компанийн дата мэдээллийн баяжилт, ажилтнуудын ур чадварын түвшин, шаардагдах нөөцийн хэмжээ, тухайн аргын үр нөлөө зэрэг чухал үзүүлэлтэд тулгуурлан өөрчилж болно.</p> <p><i>в. Мэдээлэл цуглуулахдаа дараах эх үүсвэрийг ашиглана.</i> Үүнд:</p> <ul style="list-style-type: none">- Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, хууль эрх зүйн акт;- Дотоод дүрэм, журам, стандарт, аргачлал, зөвлөмж;- Дотоод, гадаад аудит, хяналт, шалгалтын ажлын тайлан, үр дүнг харуулсан бусад материал;- Статистик тоон мэдээлэл;- Бизнесийн орчны судалгаа, дүн шинжилгээ, тэдгээрийн тайцлан, бусад материал;- Өргөдөл, санал гомдол, үл нийцлийн мэдээлэл, даатгалын тохиолдол;- Хэвлэл, нийгмийн сүлжээнд гарсан мэдээлэл;- Бусад
2.3.2	<p>Эрсдэлийн үнэлгээ хийх</p> <p>а. Бизнесийн түвшний эрсдэлийн үнэлгээний багийг Толгой компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар жил бүрийн 9-р сарын эхний 10 хоногт багтаан ирэх жилийн бизнес төлөвлөгөө боловсруулахаас өмнө багийн ахлагч, гишүүдийг томилно.</p>

б. Тактикийн болон үйл ажиллагааны түвшний эрсдэлийн үнэлгээний багийг Охин компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар жил бүрийн 1-р сарын эхний 10 хоногт багтаан багийн ахлагч, гишүүдийг томилно.

в. Томилогдсон гишүүдийг эрсдэлийн үнэлгээ хэрхэн хийх талаар сургалтад хамруулан, баримтжуулна.

г. Багийн гишүүд нь дараах шаардлагыг хангасан, эрсдэл тодорхойлж буй процессийн хариуцагч, хэрэгжүүлэгч байна. Үүнд:

- Тухайн компани, үйл ажиллагааны процесуудын талаар ойлголт, мэдлэгтэй /компанид 1 жилээс дээш хугацаанд ажилласан/

- Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, баримт бичиг боловсруулах ур чадвартай

- Судалгаа, дүн шинжилгээ, мониторинг, хяналт шалгалт, компанин бусд ажлын хэсэгт ажилласан туршалагатай байна. Багийн гишүүдийн тоо нөхцөл байдал, процессуудаас хамаарч өөр өөр байж болно.

д. Эрсдэлийн үнэлгээ хийх багийн ахлагч нь эрсдэлийн үнэлгээ хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулах, эрсдэлийн үнэлгээний ажлыг хуваарьт хугацаанд зохион байгуулж, тайлагнах үүрэг хүлээнэ.

в. Аль ч түвшний эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаа нь дараах гурван дарааллаар явагдана. Үүнд:

1. Эрсдэлийг илрүүлэх (олох, таних, тодорхойлох)

- Энэ шатны зорилго нь компани дэвшүүлсэн зорилгууддаа хүрэхэд нь туслах боломжууд эсвэл хүрэхэд саад учруулах аюулуудыг хайх, таних, тодорхойлох юм. Эрсдэлүүдийг дараах аргуудыг ашиглан тодорхойлно.

* **Нотолгоонд тулгуурласан аргууд** (өмнөх туршлага, аудиторын дүгнэлт, тохиолдож байсан алдаа, зөрчил, хохирол)

* **Шинжилгээний аргууд** (компанийн зорилго, орц, процесс, харилцан хамаарал, гадаад ба дотоод нөлөөлөл)

* **Сценарийн аргууд** (аюул, осол, үйл ажиллагааны доголдол нүүрлэсэн үед үүсэх нөхцөл байдал)

БИЗНЕСИЙН ТҮВШНИЙ ЭРСДЭЛИЙГ тодорхойлохдоо дараах алхамуудыг хийнэ. Үүнд:

- Толгой компанийн нэгж, хэлтэсүүд болон охин компаниудын /алба, нэгжээр задлаж болно/ зорилго, зорилтыг бизнес төлөвлөгөөний ажлын хүрээнд тодорхойлно.

- Тодорхойлсон зорилго, зорилтын хэрэгжилтийг хангахад нөлөөлөх нөхцөл байдлын шинжилгээг SWOT болон бусад дэвшилтэд, тохиромжтой аргачлал ашиглан хийнэ.

- Дээрх нөхцөл байдлын шинжилгээг зөв тодорхойлохын тулд гадаад болон дотоод нөхцөл байдлын дараах хүчин зүйлсийг авч үзэх боловч эдгээрээр хязгаарлагдахгүй.

- **Гадаад нөхцөл байдал** /PESTLE, Portes's 5 шинжилгээний элементүүд/

- **Дотоод нөхцөл байдал** /7S шинжилгээний элементүүд, Сонирхогч талууд/

ТАКТИКИЙН ЭРСДЭЛИЙГ тодорхойлохдоо тухайн чиг үүргийг хэрэгжүүлдэг процессийн дарааллын дагуу тодорхойлох ба энэ нь аливаа эрсдэл орхигдохоос сэргийлнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТҮВШНИЙ ЭРСДЭЛИЙГ тодорхойлохдоо тухайн чиг үүргийг хариуцдаг ажилтны ажлын байрны тодорхойлолтын дагуу гүйцэтгэх ба ажилтны аюул осолд

	<p>өртөх магадлал, хэрэгжүүлж буй хяналтын арга хэмжээний үр нөлөө, гол хяналт хэрэгжүүлэгч эсэх /ССР/, ажилдаа алдаа гаргавал гарч болох үр дагаваруудыг голлон анхаарна.</p> <p>г. Компанийн үйл ажиллагаанд өөрчлөлт орох, гадаад, дотоод орчны нөхцөл өөрчлөгдөх, томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд доголдол саатал гарсан үед эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийж бүртгэлийг шинэчлэн, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.</p> <p>2. Эрсдэлд дүн шинжилгээ хийх</p> <p>- Тодорхойлсон эрсдэлүүд нь компанийн дэвшүүлсэн зорилго, үр дүн, гүйцэтгэлд ямар хэмжээгээр нөлөөлж болохыг <i>Хавсралт.№2</i> “Эрсдэлийн нөлөөллийг тодорхойлох шалгуур”-д заасан аргачлалаар /компанийн онцлогт тохируулан өөрчилж болно/ дүн шинжилгээ хийж тохирох түвшний оноо өгнө.</p> <p>3. Эрсдэлд үнэлэлт дүгнэлт өгөх</p> <p>- Эрсдэлийн дүн шинжилгээнд тулгуурлан тухайн асуудлын “ЭРСДЭЛИЙН ЗЭРЭГ”-ийг тодорхойлно. Ингэхдээ “Үр нөлөө”-ний хэмжээг <i>Хавсралт.№3</i> “Эрсдэлийн давтамж тодорхойлох шалгуур”-ын дагуу боломжит “Магадлал”-аар үржүүлэх үржвэрийн үр дүн Min=1, Max=25 гарч болно. <i>Хавсралт.№4</i> “Эрсдэлийн үнэлгээний матриц”-г эрсдэлийн зэрэг тогтооход ашиглана.</p> <p>- Магадлалыг тооцоходоо дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ.</p> <p>* Тухайн эрсдэл өнгөрсөн хугацаанд учирж байсан давтамж</p> <p>* Ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бусад компанид тухайн эрсдэл гарч байсан эсэх</p> <p>* Тухайн эрсдэлтэй хобоотой процессийн хяналтын арга хэмжээний үр нөлөө</p>
<p>2.3.3</p>	<p>Эрсдэлийг шийдвэрлэх</p> <p>а. Эрсдэлийн зэргээс хамаарч тухайн “Аюул занал” ба “Боломж”-ийг шийдвэрлэх /бууруулах эсвэл ашиглах/ төлөвлөгөөнд оруулж, хэрэгжүүлэх эсэхээ тогтооно. 1-3 түвшний эрсдэлийг хүлээн зөвшөөрөх эрсдэл гэж үзнэ. Харин 4-25 түвшний эрсдэлийг шийдвэрлэх ажил төлөвлөж, хэрэгжүүлнэ. Эрсдэлийг шийдвэрлэхдээ <i>Хавсралт.№5</i> “Эрсдэлийг удирдах удирдамж”-д заасан ерөнхий чиглэлийг баримтлаж болох ба тэдгээрээр хязгаарлагдахгүй.</p> <p>б. Аюулыг хянах, боломжийг ашиглахдаа <i>Хавсралт.№6</i> “Эрсдэлийг шийдвэрлэх арга”-д заасан шатлалын аргачлалыг дангаар болон хослуулан /ялангуяа үйл ажиллагааны эрсдэлд/ ашиглах боломжтой.</p> <p>в. Эрсдэл бүрийг дахин давтагдахгүй дугаартай бүртгэх ба тухайн эрсдэлийн одоо байгаа хяналт, эрсдэл хариуцагчийг ажлын чиг үүрэгийн дагуу тодорхойлсны дагуу эрсдэл бууруулах төлөвлөгөө гарган батлаж, хэрэгжүүлнэ.</p> <p>г. Эрсдэл шийдвэрлэх төлөвлөгөөг хэрэгжүүлсний дараа үлдэгдэл эрсдэл ихэвчлэн гардаг тул эрсдэлийг шийдвэрлэсний дараах буурсан байдалд үнэлгээ хийж, тооцоолон баримтжуулна. <i>/Үлдэгдэл эрсдэлийг тооцоход хэцүү боловч тэдгээрийг тооцоолсноор үлдэгдэл эрсдэлийн түвшин компанийн хүлээн зөвшөөрөх түвшинд хүрсэн гэдгийг нотлох нь чухал юм/</i></p> <p>д. Хэрэв хяналтын арга хэмжээ хэрэгжүүлсний дараа үлдэх эрсдэл зөвшөөрөгдөх хэмжээнд хүрээгүй бол эрсдэлийг бүрэн шийдвэрлэх арга хэмжээ авна.</p> <p>е. Ямарч тохиолдолд үлдэгдэл эрсдэлийг компанийн гүйцэтгэх удирдлагын зүгээс хүлээн зөвшөөрч, батлаж, хянаж ажиллана.</p>

<p>2.3.4</p>	<p>Бүртгэл, тайлагнал</p> <p>а. Бизнесийн эрсдэлд толгой компани, тактикийн эрсдэлд охин компаниуд бүртгэл үүсгэх ба нэгдсэн бүртгэл хариуцах нэгж эсвэл ажилтыг томилж /АБТ-д тусгах/ <i>Хавсралт №7-д</i> заагдсан “Эрсдэлийн бүртгэл” маягтын дагуу нэгтгэгдэж, хадгалагдаж, шинэчлэгдэж байна.</p> <p>б. Бизнесийн бүртгэгдсэн эрсдэлийг жил бүрийн 1 сард, тактикийн бүртгэгдсэн эрсдэлийг 2-р сард багтааж холбогдох дотоод талуудад мэдээлэл өгч тухайн орчинд байгаа үүсч болох эрсдэлийн мөн чанарыг ажилтнуудад ойлгуулна. /Толгой болон охин компанийн ТУЗ-ийн гишүүдэд 1-р улиралын ээлжит хурлуудаар тус тус танилцуулна./ <i>КЗК 5.1 Тайлбар 1/</i></p> <p>в. Бизнесийн эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жилд хоёр удаа Толгой компанийн гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн 2 болон 4-р улиралын ээлжит хуралд танилцуулна.</p> <p>г. Тактикийн эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг улирал бүр охин компанийн гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн ээлжит хурлуудад танилцуулна.</p> <p>д. Тайлангийн агуулга дараах бүтэцтэй байна.</p> <ul style="list-style-type: none"> - Агуулга - Эрсдэлийн өөрчлөлт, шинэчлэлт - Өмнөх тохиолдлын сайжруулалт, мониторинг - Нэгж тус бүрийн өндөр түвшний эрсдэлүүд - Эрсдэлийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн үр дүн - Цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө <p>е. Яаралтай шийдвэрлэх шаардлагатай маш ноцтой эрсдэлийг ТУЗ-д тухай бүр танилцуулах ба шийдвэрийн хэрэгжилтийн явцыг 14 хоногт багтаан цахимаар танилцуулна.</p> <p>ё. Бизнесийн гол эрсдэлд бүртгэгдсэн хэт аюултай/маш өгөөжтөй эрсдэл болон байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг дараах агуулгаар боловсруулж цахим хуудсаар дамжуулж нийтэд мэдээлэх ажлыг “Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ыг баримтлан Эрсдэлийн нэгдсэн бүртгэл хариуцаж буй ажилтан хэрэгжүүлнэ. <i>КЗК 5.3/</i></p> <ul style="list-style-type: none"> - Эрсдэлийн хүчин зүйл (risk factors) - Шалтгаан нөхцөл (risk causes) - Хэрэгжүүлэх арга хэмжээ (risk drivers) зэргийг ойлгомжтой, энгийн байдлаар хавсралт хэлбэрт оруулна эсвэл “Тогтвортой байдлын тайлагналын удирдамж”-ийн дагуу дэлгэрэнгүй тайлан гаргана. <i>КЗК 5.2/</i>
<p>2.3.5</p>	<p>Эрсдэлийн мониторинг, дүн шинжилгээ</p> <p>а. Дотоод аудитор нь толгой болон охин компаниудын эрсдэлийг хянах зорилгоор авсан арга хэмжээ нь үүсч болох эрсдэлийг зөвшөөрөх хэмжээнд буюу хамгийн бага хэмжээнд байлгаж чадаж байгаа эсэхийг “Дотоод аудитын жилийн төлөвлөгөө” -нд тусгасан давтамж, хуваарийг дагуу үнэлгээ хийнэ. Энэхүү аудитын ажилд дараах хүчин зүйл хамаарна. /<i>КЗК Хавсралт 8-4.3/</i></p> <ul style="list-style-type: none"> - Эрсдэл бууруулах төлөвлөгөө нийцтэй эсэх - Хяналтын арга хэмжээний үр дүнг үнэлэх - Аюулыг хянаж өөрчлөгдсөн эсвэл шинэ аюул нэмэгдсэн эсэхийг тогтоох - Аюултай тохиолдлыг судлаж чиглэл, хандлагыг хянаж байх

	<ul style="list-style-type: none">- Хэт аюултай/маш өгөөжтэй эрсдэлийг хянах- Эрсдэл илрүүлэх, бууруулах, арилгах удирдлагын тогтолцооны үр дүнг үнэлж тайланг холбоотой талууд болон ТУЗ-ийн ээлжит хуралд танилцуулж, сайжруулах зөвлөмж өгч ажиллана.
--	---

ГУРАВ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Төлөөлөн удирдах зөвлөл

Эрх:

3.1.1 Толгой компанийн ТУЗ бизнесийн, Охин компанийн ТУЗ тактикийн түвшний эрсдэлийн үнэлгээ болон эрсдэлийн төлөвлөгөө, тайлантай ээлжит хурлаар танилцаж зөвлөмж, чиглэл гаргах

3.1.2 Эрсдэлийн үнэлгээг цаг хугацаандаа чанартай хийж гүйцэтгэхийг шаардах, ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн ажилтанд хариуцлага тооцох

Үүрэг:

3.1.3 Аюултай буюу 20-25 үнэлгээтэй эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийн тохиолдлын үед эрсдэлийн үр нөлөөллийг нэн яаралтай бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. Үлдэгдэл эрсдэлийг удирдах хяналтын арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлнэ.

3.2 Гүйцэтгэх захирал

Эрх

3.2.1 Эрсдэлийн төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлыг цаг хугацаандаа хийж гүйцэтгэхийг шаардах, ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн ажилтанд хариуцлага тооцох

Үүрэг:

3.2.2 Эрсдэлийн үнэлгээг цаг хугацаандаа чанартай хийж гүйцэтгэхийг шаардах, ажил үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн ажилтанд хариуцлага тооцох

3.2.1 Толгой компанийн Гүйцэтгэх захиарл бизнесийн, Охин компанийн Гүйцэтгэх захирал тактикийн түвшний эрсдэлийн үнэлгээ хийх багийг томилж, эрсдэлийн үнэлгээг хийнэ.

3.2.2 Эрсдэлийн үнэлгээнд эрсдэл бууруулах төлөвлөгөөг батлаж хяналт тавьж ажиллана.

3.2.3 ТУЗ-ийн ээлжит хурлаар эрсдэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хэлэлцүүлж, зөвлөмж чиглэл авна.

3.2.4 Ноцтой буюу 10-16 үнэлгээтэй эрсдэлийг аюултай түвшинд шилжихээс урьдчилан сэргийлж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авна.

3.3 Хэлтэс, нэгжийн удирдлага

Үүрэг:

3.3.1 Хариуцаж буй чиглэлийн дагуу эрсдэлийн үнэлгээг цаг хугацаанд нь гүйцэтгэх, эрсдэл бууруулах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, тогтмол хяналт тавьж ажиллана.

3.3.2 Ажилтнууддаа эрсдэлийн мэдээллийг цаг тухай бүр өгч, гарч болох эрсдэлээс сэргийлж ажиллана.

3.3.3 Анхаарал хандуулах буюу 4-9 үнэлгээтэй эрсдэлийг бууруулахад гарах өртөг болон хүртэх үнэ цэнийг хэмжиж харьцуулсаны дараа бууруулах эсэх шийдвэр гаргана. Энэ түвшиний эрсдэлийг байнгын хяналтад байлгаж, ноцтой түвшинд шилжихээс урьдчилан сэргийлж, эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

4.1 Энэ журмаар хүлээсэн эрх, үүргээ биелүүлээгүй, тогтоосон хэм хэмжээг зөрчсөн ажилтанд Хөдөлмөрийн дотоод журамд заасан сахилгын арга хэмжээнээс зөрчлийн шинж чанар, учруулсан хохирлын хэм хэмжээг харгалзан сонгож ногдуулна.

ТАВ. ХОЛБОГДОХ БАРИМТ БИЧИГ

5.1 Энэхүү баримт бичигтэй холбогдох бусад баримт бичгүүд:

5.1.1 MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежмент

5.1.2 MNS ISO 31010:2022 Эрсдэлийн үнэлгээний арга

5.1.3 Компанийн засаглалын кодекс /Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоол/

5.1.3 Аудит, эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам

5.2 Энэхүү баримт бичгийн хавсралтууд:

№	Хавсратын нэр	Дугаар
1	Эрсдэлийн удирдлагын түвшин	Хавсралт№1
2	Эрсдэлийн нөлөөллийн тодорхойлох шалгуур	Хавсралт№2
3	Эрсдэлийн давтамж тодорхойлох шалгуур	Хавсралт№3
4	Эрсдэлийн үнэлгээний матриц	Хавсралт№4
5	Эрсдэлийг удирдах удирдамж	Хавсралт№5
6	Эрсдэлийг шийдвэрлэх арга	Хавсралт№6
7	Эрсдэлийн бүртгэл	Хавсралт№7
8	SWOT шинжтлгээнд тулгуурласан бизнес эрсдэлийн үнэлгээний маягт	Хавсралт№8
9	Сонирхогч талуудын хэрэгцээ ба хүлээлтэд тулгуурласан бизнес эрсдэлийн үнэлгээний маягт	Хавсралт№9

-----oOo-----